

СЭТГҮҮЛ ЗҮЙН ДЕОНТОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН
ЗАРИМ АСУУДАЛД

М.Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор, профессор.

Түлхүүр үг: сэтгүүл зүйн деонтологи, ёс зүй, харилцааны хэм хэмжээ.

Шинжлэх ухааны эргэлтэнд одоогоос 150 жилийн өмнө орж ирсэн “деонтологи” (грекийн *deon* - үүрэг, хариуцлага + *logos* - сургаал гэсэн үг) хэмээх нэр томъёо орчин үед шинэ агуулга, утга санаагаар баяжиж, нийгмийн бүх салбар хүрээнд, түүний дотор сэтгүүл зүйд өргөн хэрэглэгдэх болжээ. Гэхдээ утга агуулгыг баяжуулах үйл явцын хүрээнд ихээхэн маргаан өрнөж, практик ажилтнууд, судлаачид янз бүрийн санал дэвшүүлж байна. Ингэх нь зүйн хэрэг. Учир нь аливаа асуудалд өөрөөр хандах явдал түүний хуучин утга агуулга нь нийгмийн өнөөгийн шаардлага, хэрэгцээг хангахгүй байгаатай холбоотой бөгөөд ийм хүчин зүйлүүдээс шалтгаалан тухайн нэр томъёог шинэ утга санаагаар баяжуулах оролдлого хийж эхэлдэг. Ийм олон янзын оролдлого нь тохиолдлын чанартай, урсгал шинжтэй, хувийн бодол давамгайлсан, сэтгэлийн хөдөлгөөнд автагдсан, хэт нэг талыг барьсан, сайн бодож боловсруулаагүй, сэтгэгдэл төдий байсан ч харж үзүүштэй өчүүхэн боловч мэдлэг, шинэлэг санааг агуулсан байдаг учраас тэднийг системчилж, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх шаардлагатай юм.

Өнөөдөр олон оронд деонтологийг уран бүтээлийн хэм хэмжээний тодорхой нэг хүрээтэй (ёс зүй, эсвэл эрх зүй г.м.), эсвэл тийм хэм хэмжээний нийлбэртэй (ёс зүй + эрх зүй + ...), эсвэл янз бүрийн хэм хэмжээний “зааг дээр” оршдог (ёс зүй ба эрх зүй г.м.) гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчийн үүрэг, зайлшгүй байх ёстой зан байдлын онцлогтой холбоотой бүх юмыг деонтологитой холбож тайлбарлах оролдлого түгээмэл юм. Үүнийг ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын биелэлтийн шинж чанарыг тодорхойлох хэм хэмжээний систем гэсэн өргөн утгаар нь авч үзсэн тохиолдолд хүлээн зөвшөөрч болно. Энэ нэр томъёог ийм өргөн хүрээнд авч үзэж байгаа учраас судлаачид янз бүрийн тодорхойлолт өгч, дүгнэлт хийдэг нь зүйн хэрэг юм. Тухайлбал, нэрт судлаач Я.Н.Засурский деонтологи бол “юны өмнө батлагдсан хуулийг хэрэгжүүлэх, ухамсарлан ойлгох явдалтай холбоотой сэтгүүлчийн хариуцлага, үүрэг, эрх мөн” гэж тодорхойлсон бол К.Крисченс, М.Трейбер нар түүнийг ёс зүйн хэм хэмжээний системтэй, Б.Михальский, В.Димитров нар хууль эрх зүйн хэм хэмжээтэй холбон тайлбарлаж, Ю.М.Батурин хууль ба ёс зүйн хэм хэмжээний хооронд оршдог хэм хэмжээний нийлбэр¹ гэж үздэг байна. Үүнийг деонтологийн асуудал бол нэлээд

нарийн төвөгтэй, нийгмийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагаас шалтгаалж, агуулга нь байнга баяжин гүнзгийрч байдаг онцлогтой холбоотой гэж ойлгож болно.

Бидний дээр дурдсан үзэл бодол, таамаглалын зөв бурууг батлахын тулд түүхэн баримтуудыг харгалзан үзэх нь чухал юм.

"Деонтологи" хэмээх нэр томъёог анх И.Бентам 1834 онд хэвлэгдэн гарсан "Deontology of the Science of Morality" ("Деонтологи, эсвэл ёс суртахууны тухай шинжлэх ухаан") номонд хэрэглэсэн бөгөөд зохиогч "хувь хүний ёс зүй

ба хууль зүйн урлаг ямагт хамт оршдог"² гэж тэмдэглэсэн нь зүй ёсоор анхаарал татах асуудал мөн. Н.Бентам "деонтологчийн гол зорилго нь нийгмийн зан байдалд хувь хүмүүсийн зан байдлын шинжийг хэвшүүлэхэд оршино" гэж тэмдэглэснийг харгалзан үзвэл "деонтологи" хэмээх нэр томъёог хамаагүй өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай гэдэг нь ойлгомжтой. Н.Бентам "Деонтологийн үндэс нь ашиг тусын зарчим бөгөөд энэ бол тодорхой үйлдэл бүр хүн төрөлхтний аз жаргалын хэмжээг ихэсгэх, эсвэл багасгахад нөлөөлөх хандлагаас шалтгаалан сайн, эсвэл муу, дэмжих, эсвэл эс дэмжих, утга учиртай эсвэл утгагүй байна гэсэн үг" гэж тэмдэглэсэн нь санамсаргүй зүйл бус бөгөөд "деонтологийн" хамгийн гол утга учир нь хувийн сонирхлыг олон нийтийн сонирхолтой хослох, хүмүүсийн хувиа хичээх, өөрийгөө бодох явдал маш хүчтэй учраас тэд зөвхөн ёс суртахууны хэм, хэмжээг удирдлага болгохын тулд

хуулийн оролцоо зайлшгүй шаардлагатай гэдгийг ойлгуулахад оршино³ гэсэн нь гүн гүнзгий утга агуулгатай юм.

Үүнээс үзэхэд деонтологийн "бүтэц, бүрэлдэхүүн"-ийг тодорхойлох явдал бүр эхнээс нь багагүй бэрхшээлтэй тулгарч байсан ба түүнийг даван туулах үйл явц тэр "бүрэлдэхүүн"-ийг хүссэн хүсээгүй өргөжин баяжуулахад хүргэжээ. Учир нь албан үүргийн асуудлуудыг боловсруулах, шийдвэрлэх явдал бол нэр томъёоны хувьд "деонтологийн" асуудал мөн бөгөөд хүн ямар нэгэн үйлдэл хийхэд юу өдүүлбэр болдог, эерэг үйлдэл

хийх, эсвэл сөрөг үйлдлээс татгалзахад юу нөлөөлдөг талаар маш өргөн мэдлэг, төсөөлөлтэй байхыг шаарддаг онцлогтой юм. Энэ ойлголтын ийм "хөдөлгөөн", түүний цаана оршдог үзэгдлийг зөв олж харах явдал ойлголтын бүрэлдэхүүнд багтдаг хэсгүүдийг олон янзаар тодорхойлох, ойролцоо утгатай

«
"Деонтологи" хэмээх нэр томъёог анх И.Бентам 1834 онд хэвлэгдэн гарсан "Deontology of the Science of Morality" ("Деонтологи, эсвэл ёс суртахууны тухай шинжлэх ухаан") номонд хэрэглэсэн бөгөөд зохиогч "хувь хүний ёс зүй ба хууль зүйн урлаг ямагт хамт оршдог" гэж тэмдэглэжээ
»

олон нэр томъёо хэрэглэхээс сэргийлэх боломж олгох байсан юм. Гэвч ойлголтыг тодорхойлох үйл явц арай өөр чиглэлээр явсан бөгөөд "деонтологиор" тодорхой нэг шинжлэх ухааны салбарыг бус (ёс зүй, эрх зүй г.м.), мэргэжилтний хариуцлага, үүрэг гүйцэтгэх явцад зайлшгүй баримтлах хэм хэмжээний тухай ёс зүйн төсөөллийн зөвхөн тодорхой нэг хэсгийг нэрлэж байжээ. Харин шинжлэх ухааны дотор тодорхой ялгарал явагдаж, судлах зүйлийн онцлогийн дагуу төрөлжиж эхэлсэн үед деонтологийн судлагдахуун болох ёс зүйн хариуцлагын тухай сургаал хэт хязгаарлагдмал болж, ёс зүйд "деонтологи" хэмээх ойлголт онцын шаардлагагүй болов. Тиймээс ч

нэг хэсэг энэ нэр томьёо ёс зүй судлаачдын үгийн сангаас бүрэн арилсан билээ. Гэвч "деонтологи" хэмээх өвөрмөц шинжлэх ухааны талаарх үзэл санаа устаж арилаагүй, харин өөрийнхөө "нууц амьдрал"-ыг үргэлжлүүлсээр байв. Тийм нууц үе хэдэн арван жил үргэлжилсэн ч эцсийн эцэст деонтологи нийгмийн практикийн янз бүрийн хүрээг (анагаах ухаанаас эхлээд спорт хүртэл) хамарсан шинжлэх ухааны маш чухал салбар гэдгийг судлаачид ч, практик ажилтнууд ч хүлээн зөвшөөрсөн билээ.

Нийгмийн практикийн хүрээн дэх үүрэг, хариуцлагын асуудлыг авч үздэг мэдлэгийн систем дэх шинжлэх ухааны өвөрмөц салбар болох "деонтологийн" тухай төсөөлөл өнөөдөр хүртэл үргэлжилж, аажим аажмаар өргөн хүрээг хамрах болсон нь санамсаргүй зүйл огтхон ч биш юм.

Мэдлэгийн системд хандаж байсан эртний бүтээлүүд, лавлах материалуудыг өнгөцхөн гүйлгэж харах явцад зан байдлын байх ёстой хэм хэмжээний тухай төсөөлөл нэгдмэл нэг л ойлголтын хүрээнд эргэлдэж байсныг амархан ажиглаж болно. Эртний ёс зүйг судлаач эрдэмтний нэгэн бүтээлд "Сократ Күнзийн нэгэн адил ёс суртахуун ба эрх зүй нягт уялдаа холбоонд оршдог"⁴ гэж бичсэн бол судлаачид Эртний Грек, Дорно дахинд гүн ухаан, ёс зүй, эрх зүй нэгдмэл нэг л зүйл байсан бөгөөд бүгд нийлж хүмүүст практик сургаал, зөвлөмж өгч байсныг олж тогтоожээ. Тэгвэл шинжлэх ухаанд "ёс зүй" хэмээх нэр томьёог анх оруулсан Аристотель түүнийг сэтгэл санаа болон төрийн тухай сургаалын дунд оршдог ба гол зорилго нь шударга сайн иргэнийг төлөвшүүлэх явдал гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, улс төр, эрх зүй, ёс зүй гурав нийлж, "үнэн зөв хэм хэмжээний" тухай төсөөлөл өгдөг "хүн төрөлхтний нэгдмэл гүн ухааныг" бүрдүүлж байв. Харин олон зуун жилийн дараа Кант ёс

зүйг зайлшгүй байх ёстой зүйлийн тухай шинжлэх ухаан бөгөөд түүний цөм нь хүн үүргээ биелүүлэх дотоод итгэл үнэмшлийн тухай төсөөлөл гэсэн дүгнэлт хийжээ.

Бид энэхүү "мэдээлэл"-д тулгуурлан наад зах нь хоёр төрлийн дүгнэлтийг урьдчилж хийж болно. *Нэгдүгээрт*, деонтологи нь маш эртний ойлголт бөгөөд анх хүн төрөлхтөн үүсэн бий болох үед зан байдлын зайлшгүй байх ёстой хэм хэмжээний тухай мэдлэгийн нийлбэр хэлбэрээр бий болжээ. Дараа нь жам ёсны хуулиар нэгдмэл мэдлэг нь шинжлэх ухааны бие даасан салбар болон задарч төрөлжсөн түүхтэй юм. *Хоёрдугаарт*, үйл ажиллаганы дүрэм журам, зарчмуудын систем болох зан байдлын шаардлагатай хэм хэмжээ, үүрэг, хариуцлагын тухай нэгдмэл төсөөлөлтэй байх дотоод хэрэгцээ, шаардлага байнга оршиж байдаг. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны төрөлжсөн салбар бүрт тусгасан үйл ажиллагааны хариуцлага, зан байдлын хэм хэмжээний тухай мэдлэгийг нэгтгэж нэгдмэл нэг төсөөлөлтэй байх шаардлага аяндаа гарчээ.

Деонтологийг нийгмийн амьдралын шинэ нөхцөлд дахин сэргээж хэрэглэсэн салбар бол анагаах ухаан юм. Тавиад оны үед Н.Н.Петров анагаах ухааны сургуулиудад "деонтологийн" тухай хичээл оруулж, "эмч—эмч", "эмч—өвчтөн", "эмч—өвчтний төрөл садан" зэрэг харилцааны хэм хэмжээнээс эхлээд эрүүл мэндийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлэхэд баримтлах дүрэм журмыг хүртэл тодорхойлох оролдлого хийсэн юм⁵. Энэ бүтээлийн дараа дээрх асуудлын хүрээнд цөөнгүй материал нийтлэгдэж, нэлээд ширүүн маргаан мэтгэлцээн өрнөсөн ажээ. Сүүлд энэ нэр томьёог нийгмийн практикийн бусад салбарт өргөн хэрэглэх болсноор шинэ утга агуулгаар баяжиж, түүнийг янз бүрээр тодорхойлж эхэлсэн түүхтэй юм. Гэвч тийм тодорхой-

лолт, шинж чанар, үзэл бодолд багагүй зөрчил, хэт явцуу эсвэл өргөн хүрээний тодорхойлолт, шинж тэмдэг, бүтцийн элементүүдийг өнгөцхөн тоочсон системгүй байдал ажиглагддагийг тэмдэглэх хэрэгтэй. Тийм үзэл бодол, тодорхойлолт, шинж тэмдгүүдийг нэгтгэн дүгнэх замаар дараах гурван зүйлд анхаарлаа хандуулах шаардлагатай юм. Үүнд:

Нэгдүгээрт, нийгмийн практикийн тодорхой нэг "хүрээнд" үйлчилдэг аливаа шинжлэх ухаанд (анагаах ухаан, хууль зүй, сурган хүмүүжүүлэх ухаан, бизнес, удирдлагын ухаан г.м.) ямар нэгэн өвөрмөц салбар ухаан болж төрөлжих хэрэгцээ шаардлага бий болсон бөгөөд үүнийг Бентамын нэр томъёог ашиглан "деонтологи", эсвэл "ёс зүй" гэж нэрлэжээ. Гэхдээ энэ бол асуудалд хэт өнгөцхөн хандсан, зөвхөн зарим нэг шинж тэмдгийг харгалзан үзсэн явдал байсан юм.

Хоёрдугаарт, ёс зүйн болон эрх үйн харилцаа, удирдах болон ажил хэргийн харилцаа холбоо, найз нөхдийн болон гэр бүлийн харилцаа зэрэг тодорхой нэг хэм хэмжээнд оруулах боломж бүхий нийгмийн салбар, хүрээтэй харьцуулан үзвэл деонтологийн "хэм хэмжээ, дүрэм журам" хамаагүй өргөн хүрээг хамрах бөгөөд нэгдмэл, төгс төгөлдөр системд оруулах боломжгүй. Тиймээс судлаачид цэвэр ёс зүйн, эрх зүйн, удирдлагын болон бусад хэм хэмжээний хамт ёс зүйн хэм хэмжээ, оюуны чадавхи, үзэл бодол, байр суурь, сэтгэл зүйн онцлог шинжүүдэд ханддаг нь санамсаргүй зүйл биш юм. Тэгвэл деонтологийн хүрээнд багтдаг өргөн утга агуулга бүхий олон янзын онцлог шинжүүд бол энэ салбарын гол асуудал бөгөөд түүнийг тусгайлан судлах шаардлагатай юм.

Гуравдугаарт, Орчин үед деонтологийн тухай ярихдаа юуны өмнө түүний үйлчлэх хүрээг хамрах шинжлэх ухааны салбарыг (анагаах ухаан,

сурган хүмүүжүүлэх ухаан, хууль зүйн, сэтгүүл зүй г.м.) тодорхойлох нь түгээмэл юм. Энд асуудлын хамгийн гол утга учир нь "нийтлэг, ерөнхий" деонтологи байх ёсгүй гэдэгт оршино. Гэхдээ практикийн тодорхой хүрээнд мэргэжилтний байх ёстой зан байдлын тухай мэдлэгийн системийг тодорхойлохдоо энэ ойлголтыг нарийвчлан авч үзэх шаардлага зайлшгүй гардаг. Тиймээс "Деонтологи гэдэг бол мэргэжилтний байх ёстой зан байдлын зарчим, хэм хэмжээ, шаардлагуудын систем бөгөөд нийгмийн бодит практик дахь хүмүүсийн зан байдлын хэм хэмжээ, үүрэг, хариуцлагын талаарх шинжлэх ухааны мэдлэгийн систем дэх хэрэгцээ, шаардлагаас шалтгаалан сургалт болон шинжлэх ухааны тодорхой салбар болж төлөвшсөн"⁶ гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Деонтологи тухайн мэргэжлийн тавьж буй шаардлага, мөн мэргэжилтний үйл ажиллагааг амжилттай явуулахад шаардлагатай хариуцлага болон эрх үүргийн тухай нэгдмэл мэдлэг өгдөг шинжлэх ухааны салбар мөн. Энэ бол субъектив шинжтэй онол бөгөөд аливаа үйл ажиллагааны хүрээний объектив хуулиудыг мэргэжилтний албан үүрэг, зан байдлын хэм хэмжээ рүү "шилжүүлсэн" гэж хэлж болно. Сэтгүүл зүйн шинжлэх ухаан болон сэтгүүлчийн үйл ажиллагаа өөрийнхөө деонтологийн асуудлуудыг илрүүлэх, танин мэдэх, судлах аргын хувьд бусад шинжлэх ухаан, практик үйл ажиллагаагаас зарчмын ялгаагүй юм.

Ө нөөдөр "деонтологи" хэмээх нэр томъёо сэтгүүл зүйн судлалд нэлээд эрчимтэй нэвтэрч эхэлсэн боловч практик сэтгүүл зүйд харьцангуй бага хэрэглэгддэг. Гэвч нийгэмд гарсан өөрчлөлт, сэтгүүлчдийн дунд бий болсон нөхцөл байдал, тэдний нийгмийн хариуцлага, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах төвшин зэргэгт

хийсэн ажиглалт, судалгааны дүн зэрэг нь деонтологийн асуудал сэтгүүл зүйн практик үйл ажиллагааны хамгийн тулгамдсан асуудал гэдгийг харуулж байна. Тиймээс сүүлийн жилүүдэд сэтгүүл зүй судлаачид энэ асуудалд ихээхэн анхаарч, судалгааны бие даасан объектын хувьд ханддаг болжээ. Үүний тодорхой жишээ бол сэтгүүлчийн ёс зүй, нийгмийн хариуцлага, ОНМХ-ийн эрх зүйн зохицуулалтын талаар янз бүрийн төсөл хэрэгжүүлж, ном, гарын авлага бэлтгэх, сургалт семинар, эрдэм

шинжилгээний бага хурал зохион байгуулах явдал идэвхжиж, сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт энэ чиглэлээр хичээл орж эхэлсэн явдал юм. Нөгөө талаар энэ асуудлыг зөвхөн сэтгүүл зүй судлаачид, сэтгүүлчид төдийгүй, хуульч, сэтгэл судлаач, сурган хүмүүжүүлэгч, удирдлагын

ухааны мэргэжилтнүүд зэрэг бусад салбарын хүмүүс сонирхож, янз бүрийн маргаан, мэтгэлцээн өрнүүлж буй нь деонтологи хэр зэрэг тулгамдсан асуудал болж байгаагийн илрэл мөн.

Орчин үед сэтгүүл зүйн деонтологийн асуудлыг боловсруулахад тулгарч буй хамгийн гол бэрхшээл бол сэтгүүлчдийн нэгдсэн корпораци (холбоо, эвсэл, нэгдэл г.м.) жинхэнэ ёсоор оршин тогтнож чадах явдалтай холбоотой юм. Хэрэв сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалж чаддаг тийм корпораци байгаа нөхцөлд сэтгүүл зүйн нэгдсэн деонтологийн тухай ярьж болно. Харин сэтгүүлчдийг нэгтгэж чадсан тийм байгууллага байгаагүй

нөхцөлд деонтологийн тухай ярих боломжгүй бөгөөд түүний гол асуудал, хэм хэмжээг зөвхөн хуулийн хүрээнд зохицуулах шаардлага гардаг.

Сэтгүүлчдийн корпораци бодитой оршин тогтнох хамгийн гол нөхцөл нь бүх сэтгүүлчдэд сэтгүүл зүйн гүйцэтгэх үүрэг, нийгмийн бусад институтуудын дотор эзлэх байр, бүтээлч үйл ажиллагааны шинж чанартай холбоотой ямар нэгэн нийтлэг зүйл байх явдал юм. Энэ бол "төр засаг ба ОНМХ"-ийн хоорондох харилцаатай холбоотой сэт-

гүүлчийн нийгмийн эрх ашгийг хамгаалах, дарамт шахалтаас ангид бие дааж чөлөөтэй хөгжих боломжийг бүрдүүлэх, чөлөөт хэвлэлийг жам ёсоор нь хөгжүүлэх зэрэг нийтлэг зүйл байж болно. Ер нь иргэний нээлттэй нийгэм чөлөөтэй хөгжих үйл явц хүссэн хүсээгүй сэтгүүлчид ямар нэг байдлаар нэгдэн

нийлэхэд зайлшгүй нөлөөлдөг онцлогтой. Ийм нэгдэл болгонд тухайн байгууллагын мөн чанар, онцлог шинжийг илэрхийлдэг деонтологийн үзэл санааг нэгтгэх, боловсруулах, системчлэх, шүүмжлэлтэй хандах, гүнзгийрүүлэн хөгжүүлэх, тодорхой нэг баримт бичгийн хэлбэрт оруулах шаардлага аяндаа бий болдог. Тийм баримт бичгүүд ёс зүйн кодекс, удирдамж, зөвлөмж, дүрэм журам, мэргэжилтний баримтлах зарчим, хууль эрхийн баримт бичгийн эмхэтгэл зэрэг маш олон янз байж болно.

Сэтгүүл зүйн деонтологийн баримт бичиг нь сэтгүүл зүйн байгууллага, холбоо, нийгэмлэгийн нэгэн адил

«

***Орчин үед сэтгүүл зүйн
деонтологийн асуудлыг
боловсруулахад тулгарч буй хамгийн
гол бэрхшээл бол сэтгүүлчдийн
нэгдсэн корпораци (холбоо, эвсэл,
нэгдэл г.м.) жинхэнэ ёсоор оршин
тогтнож чадах явдалтай
холбоотой юм. Хэрэв сэтгүүлчдийн
эрх ашгийг хамгаалж чаддаг тийм
корпораци байгаа нөхцөлд сэтгүүл
зүйн нэгдсэн деонтологийн тухай
ярьж болно.***

»

нэгдмэл цул шинжтэй байх боломж маш хязгаарлагдмал юм. Олон улгалыч үзлийг эрхэмлэн дээдэлдэг ардчилсан нийгэмд олон янзын үзэл бодол зайлшгүй шаардлагатай боловч тийм үзэл бодлын системийн "цөм" нь болох учиртай нэгдмэл санаа бодлын төв байх нь бүр ч чухал гэдэг нь ойлгомжтой. Сэтгүүл зүйн деонтологийн хувьд тийм "цөм" нь бүх зарчмын хувьд нийтлэг зүйл байхыг илэрхийлдэг бөгөөд энэ нь түүнийг тухайн байгууллагын онцлогт тохируулан төрөлжүүлж, улам нарийвчилж, зөөлрүүлж, эсвэл улам хүндрүүлж хэрэглэнэ гэсэн үг юм. Энд деонтологийн мэдлэгийн систем нь сэтгүүлчдийн хамгийн гол байгууллагын онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр өрнөдөг.

Ер нь сэтгүүлчдийн корпорацийн (эсвэл холбоо, эвсэл г.м.) үйл ажиллагааг нэлээд нарийн төвөгтэй гурван төрлийн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг гэж хэлж болно. Энэ бол тухайн байгууллагыг бүхэлдээ хамарсан нийтлэг зүйл, тэднийг бүрдүүлж буй бие даасан нэгжүүдийн онцлогийг харгалзан үзсэн зүйл, тодорхой тохиолдол дахь хувь хүний зан байдал, үйлдлийн онцлог шинж зэрэг хоорондоо салшгүй холбоотой хүчин зүйлүүдийн нэгдэл мөн. Энэ бүхэн нь сэтгүүл зүйн деонтологийн онолын баазыг бүрдүүлэх, нийтлэг болон тодорхой нэгжийн деонтологийн баримт бичгийг боловсруулах, сэтгүүлчдийн байгууллага, сэтгүүлчдийн үйл ажиллагааг үнэлэх шалгуурыг тогтооход ихээхэн хүндрэл учруулж болно. Гэхдээ энэ бол сэтгүүлчдийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй илэрдэг бодит бэрхшээл учраас түүнийг ямар нэг аргаар даван туулах шаардлагатай бөгөөд деонтологийн онол, баримт бичиг, практикийн аль алинд нь зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай юм.

Сэтгүүл зүйн деонтологийн асуудлыг боловсруулахдаа янз бүрийн

аргаар хандаж болно. *Нэгдүгээрт*, сэтгүүлчдэд тавигдах шаардлага, үүрэг, эрх, хариуцлага, зан байдлын хэм хэмжээний талаар мэргэжлийн байгууллагуудын ёс зүйн баримт бичгүүд, судалгааны бүтээл, хууль эрхийн актуудад тусгасан бүх зүйлийг эмхэтгэн найруулж, нэгдсэн баримт бичигтэй болох. *Хоёрдугаарт*, нийгмийн практикийн бусад салбаруудад боловсруулж бий болгосон деонтологийн судалгаатай (анагаах ухаан, сурган хүмүүжүүлэх ухаан г.м.) адил сэтгүүлчдэд тавигдах шаардлагын системийг боловсруулах. *Гуравдугаарт*, сэтгүүл зүйн практикт тааралддаг хамгийн сайн, шилдэг жишээ, баримтуудыг цуглуулж, задлан шинжилж, дахин хянан боловсруулах. *Дөрөвдүгээрт*, сэтгүүл зүйн деонтологийн асуудлыг системтэй боловсруулахдаа бусад бүх хандлага, арга барилын хамгийн оновчтой, хэрэгтэй зүйлийг сонгон авч бүтээлчээр хэрэглэх өргөн боломжтой бөгөөд онолын хувьд нэлээд тогтвортой, үндэс суурьтай байгааг харгалзан үзэх шаардлагатай юм. Энэ бүхэн нь бусад салбарын туулж өнгөрүүлсэн олон арван жилийн хугацааг давтахгүйгээр сэтгүүл зүйн деонтологид хуримтлагдсан мэдлэгийг оновчтой ашиглах замаар онол, практик, арга зүйн асуудлыг харьцангуй богино хугацаанд боловсруулахад нөлөөлөх болно. Хамгийн гол нь дээрх аргуудын аль алиныг хослон хэрэглэх нь чухал юм.

Сэтгүүл зүйн деонтологийг шинжлэх ухааны онолын мэдлэгийн төвшинд боловсруулах явдал түүний хамгийн гол, үндсэн ойлголтыг тодорхойлж, категориудыг илрүүлэхийг зүй ёсоор шаарддаг. Деонтологийн хамгийн гол ойлголт нь "үүрэг" бөгөөд "ашиг тус", "сайн сайхан", "муу муухай" зэрэг ойлголттой нягт уялдаа холбоонд оршдог нь тодорхой юм. Шинжлэх ухаанд "үүрэг" хэмээх ойлголтыг гол төлөв ёс зүйн

үзэл баримтлалын хүрээнд авч үздэг нь түгээмэл ажиглагддаг. Гэвч хүний албан үүрэг, үйл ажиллагаа нийгмийн амьдралын бүх салбарыг хамардаг, маш өргөн хүрээтэй учраас энэ ойлголтыг универсаль шинжтэй гэж хэлж болно. Иргэний үүрэг, гэр бүлийн үүрэг, албан ажлын үүрэг, мэргэжлийн үүрэг, найз нөхдийн үүрэг гэж ярьдаг нь ч үүнтэй холбоотой юм.

Сэтгүүлчийн үүрэг бол нийгмийн өвөрмөц институт болох сэтгүүл зүйн үйл ажиллагааны хууль, зүй тогтлоор тодорхойлогддог мэргэжлийн бүх төрлийн харилцааны явцад биелүүлэх албан үүргийн нийлбэр мөн. Тэгвэл сэтгүүлчийн албан ажлын орон зай сэтгүүл зүйн нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, эзлэх байр сууринаас шалтгаалан сэтгүүлчийн хөдөлмөрийн бүх хүрээ болон ухамсрыг хамрах болно. Хэрэв албан үүргийн объектив агуулга нь нийгмийн бодит шаардлагаас шалтгаалдаг бол субъектив утга нь нийгмийн харилцааны туйлын зорилго, түүнд хүрэх арга хэрэгсэл, хувь хүний онцлог шинж чанарын талаарх ойлголт, төсөөллөөс шууд шалтгаалдаг байна. Тиймээс сэтгүүлчийн хувьд зорилгод хүрэх, сайн үйлс бүтээхэд нөлөөлөхөд чиглэгдсэн эцсийн зорилго, зан байдлын хэм хэмжээний талаарх төсөөлөл, мэдлэг онцгой үүрэг гүйцэтгэх онцлогтой юм.

Сэтгүүлчийн нийгмийн өмнө хүлээсэн үүргийн төлөө *хариуцлагын* асуудал ч дээрх дүгнэлтээс урган гардаг. "Media and Democracy" хэмээх бүтээлд "Хариуцлага бол илтгэлцэл төрүүлдэг. Илтгэлцэлгүй сэтгүүлчид олон түмнийг мэдээллээр хангах өөрсдийн хамгийн гол үүргийг биелүүлэх боломжгүй"⁷ гэж тэмдэглэсэн нь санамсаргүй зүйл биш юм. Ингэхдээ "гадаад" хариуцлага нь хууль эрх зүйн актууд, ёс зүйн хэм хэмжээ, бусад дүрэм журмаар тодорхойлогддог бол "дотоод" хариуцлага нь сэтгүүлчийн итгэл үнэмшлийн системээр тодорхойлогдох

болно. Энэ нь зарим тохиолдолд давхацдаг бол, заримдаа хоорондоо зөрчилдөх, сөргөлдөх явдал ч тохиолддог.

Сэтгүүлчийн үүргийг ардчилсан нийгмийг мэдээллээр хангах, "мэдээллийн дэг журмыг" бий болгоход үйлчлэгч гэсэн утгаар тодорхойлох нь сэтгүүл зүйн деонтологийн хүрээнд багтдаг эрх, үүрэг, зөвшөөрөгдсөн, хориглосон болон бусад асуудлын талаарх төсөөллийг боловсруулахад нөлөөлдөг зарчмын чухал үндэс болдог. Энд зарчмын гэдэг үгийг онцлон тэмдэглэх шаардлагатай. Учир нь деонтологийн тухай төсөөлөл, сэтгүүлчийн зан байдлын хэм хэмжээний асуудлыг маш тодорхой, оновчтой боловсруулах ажил сэтгүүлчийн үүрэг, хариуцлагыг сэтгүүл зүйн үйл ажиллагааны зүй тогтлуудын дагуу ухамсарлан ойлгохгүйгээр хийгдэх боломжгүй юм.

Сэтгүүлчийн "дөрөв дэх засаглал"-ын төлөөлөгчийн хувьд олон нийтийн мэдээллийн үйл явцад болон сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүргийг биелүүлэх, нийгмийн байр суурийг бүрдүүлэх, хэрэгжүүлэхэд оролцох, өөрийнхөө үйл ажиллагаанд эрх чөлөөг хэрэгжүүлэх арга зам, түүний мөн чанар, нийтлэлийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хүлээн авагчидтай ажиллах арга хэлбэр, мөн өөрийнхөө оюуны ба уран бүтээлийн чадавхийг сэтгүүл зүйн онцлогт тохируулан ашиглах үйл явцын шинж чанар зэрэг нь деонтологийн асуудлын хүрээнд багтах болно. Ийм үйл ажиллагааны явцад гаргасан шийдвэр нь сэтгүүлчийн үүргийн хүрээнд багтдаг бөгөөд ОНМХ-ийн нийгмийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх үйл явцтай салшгүй холбоотой учир гадаад дүрхийн хувьд ч деонтологийн шинж тэмдэг илэрдэг онцлогтой. Тийм учраас деонтологийн аливаа категори нь сэтгүүлчдийн байгууллага, редакцийн хамт олон, хувь хүний гэсэн гурван

төрлийн онцлог шинжийг нэгэн зэрэг агуулдаг бөгөөд сэтгүүлчийн практик үйл ажиллагааг деонтологийн үүднээс үнэлэх нь нэг бус, гурван өөр шалгуурын нийлбэр байх учиртай юм.

Сэтгүүл зүйн деонтологийн асуудлыг боловсруулах, түүнийг тодорхой хэм хэмжээний шаардлагуудын төвшинд хүргэж хэвшүүлэх нь сэтгүүлч бүрийн мэргэжлийн үүргийн биелэлтийн шинж чанарыг тодорхойлдог. Энэ нь тухайн сэтгүүлчийн ОНМХ-ийн нийгмийг мэдээллээр хангах үүргийг гүн гүнзгий ухамсарлан ойлгох явдлаас шууд шалтгаалдаг.

Үүнээс үзэхэд сэтгүүл зүйн деонтологи ХМХ-ийн хамт олныг бүрдүүлэгч сэтгүүлчийн хувийн онцлог шинж буюу нийгмийн байр суурь, сэтгүүлчийн авьяас, чадвар, мэргэжлийн сонирхол зэрэг гурван хүчин зүйлтэй салшгүй

холбоотой байна. Учир нь энэ гурван хүчин зүйл сэтгүүлчийн мэдлэг, чадвар, боловсрол зэрэг хамгийн гол шинжийг бүрдүүлдэг бөгөөд түүнд мэргэжлийн шинж чанар, ерөнхий болон тусгай мэдлэг, дадал, чадвар, мэргэжлийн туршлага, мэргэжлийн хариуцлагыг ухамсарлан ойлгосон байдал зэрэг харьцангуй бие даасан шинжүүд төвлөрдөг юм.

Явцуу утгаар нь авч үзвэл иргэний, эрх зүйн, ёс зүйн, захиргааны зэрэг хариуцлагын "нийлбэр" деонтологитой шууд холбоотой мэт боловч сэтгүүл зүйн практикт хариуцлагын бусад төрөл ч энэ ойлголттой салшгүй холбоотой байдаг нь ажиглагддаг.

Сэтгүүлчид деонтологийн мэдлэг, түүнд тохирсон практик орчин шаардлагатай бөгөөд түүнийг эзэмшсэнээр тодорхой дадлага, туршлагыг бий болгодог. Гэхдээ зайлшгүй шаардлагатай мэргэжлийн шинж чанар, чиглэсэн зорилго бүхий хүчин чармайлт, идэвх зүтгэлгүйгээр мэдлэг ба туршлага юу ч биш байдаг нь батлагдсан зүйл. Өөрөөр хэлбэл, нийгмийн байр суурь, чадвар, хүсэл сонирхол, чиглэсэн зорилгоо деонтологийн үүднээс боловсруулаа-

гүй нөхцөлд мэдлэг, туршлага хоёр "ажиллахгүй" гэсэн үг юм. Тухайлбал, хүсэл сонирхол ямар нэгэн учир шалтгааны үндсэн дээр бий болдог бол шалтгаан хувийн болон нийгмийн үүрэг, зорилгын талаарх төсөөллөөс шууд шалтгаалдаг.

Сэтгүүлчийн албан үүргийн систем нь түүний үйл ажиллагааны бүх чиглэл, бие

«

Явцуу утгаар нь авч үзвэл иргэний, эрх зүйн, ёс зүйн, захиргааны зэрэг хариуцлагын "нийлбэр" деонтологитой шууд холбоотой мэт боловч сэтгүүл зүйн практикт хариуцлагын бусад төрөл ч энэ ойлголттой салшгүй холбоотой байдаг нь ажиглагддаг. Сэтгүүлчид деонтологийн мэдлэг, түүнд тохирсон практик орчин шаардлагатай бөгөөд түүнийг эзэмшсэнээр тодорхой дадлага, туршлагыг бий болгодог.

»

хүний бүх онцлог шинжийг хамардаг гэж үзвэл сэтгүүл зүйн деонтологийн талаар тодорхой дараалалтай, бүрэн төгс төсөөлөл өгөх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Харин деонтологи сэтгүүлчийн үйл ажиллагааны "үүрэг, хариуцлагатай" салшгүй холбоотой бөгөөд сэтгүүлч үүргийг хэрэгжүүлэгч, биелүүлэгч гэсэн ойлголтын үүднээс хандвал деонтологийн асуудлыг бүрэн гүйцэд биш юмаа гэхэд харьцангуй өндөр төвшинд боловсруулах боломжтой юм. Гэхдээ деонтологийн асуудлыг тодорхой дэс дарааллын дагуу авч үзэх нь чухал гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Ингэхдээ юуны өмнө дараах хэд хэдэн асуултанд хариулт өгөх

шаардлагатай болно. Үүнд: *Нэгдүгээрт*, деонтологийн "орон зайг сэтгүүлч өөрийнхөө үүрэг, зорилгыг биелүүлэхийн тулд оролцож буй мэргэжлийн харилцаатай холбон тодорхой бүтцийн системд оруулах явдал юм. Энэ бол "эмч—өвчтөн", "цагдаа—гэмт хэрэгтэн", "сэтгүүлч—хүлээн авагч" гэх мэт хоёрдмол харилцаанд оршдог бөгөөд тийм харилцаа бүрийн агуулгыг тодорхойлох шаардлага гардаг. Ийм хоёрдмол харицлааг илэрхийлэх харьцангуй амархан бөгөөд деонтологийн асуудал нь гол хоёр хүрээнд оршдог байна. Нэг дэх нь харилцааны гадаад талыг илэрхийлэн, "ХМХ—төр засаг", "ХМХ—нийгэм", "ХМХ—нийгмийн институт", "ХМХ—иргэд" хэмээх хүрээнд оршдог бол хоёр дахь нь дотоод талыг илэрхийлж, тэдний агуулгыг улам тодруулж өгдөг. Үүнд "сэтгүүлч—эрхлэн гаргагч", "сэтгүүлч—хүлээн авагч", "сэтгүүлч—бодит байдал" болон түүнээс урган гарсан "сэтгүүлч—мэдээллийн эх сурвалж", "сэтгүүлч—бүтээлийн баатар", "сэтгүүлч—хамтран ажиллагсад", "сэтгүүлч—реклам олгогч" зэрэг харилцаа багтдаг. Гэхдээ ийм харилцаа маш олон бөгөөд бид зөвхөн хамгийн гол харилцаануудыг дурдсан болно.

Хоёрдугаарт, өөр нэг чухал асуудал бол хоёрдмол харилцааны дотоод агуулгыг нарийвчлан тусгах явдал бөгөөд энд харьцангуй олон бэрхшээл тулгарч багагүй хүндрэл учрах магадлал өндөр. Энэ нь хоёрдмол харилцааны тодорхой хэсгийг гэрээ бүхий этгээдүүд эзэлдэгтэй холбоотой юм. Тухайлбал, "ХМХ-төр засаг" гэсэн харилцааны хоёр "гишүүнийг" авч үзвэл энэ хүрээнд оршдог албан үүргийн, ажил төрлийн харилцааг тодруулах нь багагүй хүч, хөдөлмөр шаарддаг нь тодорхой. Энд ХМХ-ийн Үндсэн хууль болон бусад эрх зүйн актуудад хандах хандлага, ХМХ-ийн засаглалсан системд эзлэх байр, "дөрөв дэх засаглалын" үүрэг, иргэд

болон нийгмийн институтуудад зэрэг өргөн хүрээг хамарсан харилцаанд зайлшгүй байх ёстой хэм хэмжээ, шаардлагуудыг яв цав тодорхойлох боломжгүй юм. Харин шаардлагуудыг системчлэх замаар зарчим болон хэм хэмжээний хүрээнд авч үзэх нь дээр харилцаануудын агуулгыг илүү тодорхой илэрхийлэх болно. Зарчим үйл ажиллагааны үндэс (латины *principium* - "үндэс" гэсэн үг) болохын хувьд аль ч хүрээн дэх үүргийн биелэлтийн шинж чанар, агуулгыг илэрхийлдэг. Үнэн бодитой байх, эсвэл хүнлэг байх, олон ургальч үзэл эсвэл ил тод байх зарчим сэтгүүл зүйн үйл ажиллагааны бүх хүрээ, үе шатанд ил, далд ямар нэг байдлаар зайлшгүй үйлчилдэг. Эс тэгвэл тэд сэтгүүл зүйн деонтологийн бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үндэс, зарчим болж чадахгүй юм. Тэгвэл үүрэг, эрх, хориглосон эсвэл зөвшөөрсөн зүйл, шаардлага, хязгаарлалт, стандарт, чиг баримжаа зэрэг хэлбэрээр оршдог тэр тусмаа дүрэм журам бол харилцааны тодорхой хүрээнд үйлчилдэг онцлогтой.

Энэ бүхнээс үзэхэд деонтологийн асуудлыг боловсруулах үйл явц, *нэгдүгээрт*, деонтологи бол ХМХ-ийн уг мөн чанараас шалтгаалан сэтгүүлч нийгмийн тодорхой нэг нөхцөл, тохиолдолд үүргээ биелүүлэхэд зайлшгүй үйлчилдэг хэм хэмжээ, шаардлагуудын нийлбэр мөн гэж ойлгох явдлаас шалтгаалдаг. *Хоёрдугаарт*, деонтологи бол сэтгүүлчийн үйл ажиллагааны хариуцлагын системийн тухай шинжлэх ухаан мөн. *Гуравдугаарт*, хүлээн зөвшөөрөгдсөн хариуцлагын хэм хэмжээний системийг тусгасан баримт бичгүүдийн нийлбэрийг бас деонтологи гэж ойлгож болно. *Дөрөвдүгээрт*, сэтгүүл зүйн үйл ажиллагааны субъектуудын хариуцлагыг ухамсарлан ойлгосон, түүнийг практикт хэрэгжүүлэх явцад илрэх зан байдлын шинж чанар юм. Энэ чиглэл,

төсөөллүүдийн зааг дээр деонтологийн тухай ойлголт жинхэнэ утгаараа бүрэлдэн тогтох ёстой. Хэрэв бид энэ байр суурийг хүлээн авсан нөхцөлд деонтологийн мөн чанарын дараах чухал асуудал болох деонтологийн шаардлагатай баримт бичгийн тухай асуудал зайлшгүй гарч ирнэ. Сэтгүүлчдийн байгууллагууд хариуцлагын хэм хэмжээг харти, кодекс, дүрэм, удирдамж, зөвлөмж, санамж, тунхаглал зэрэг янз бүрийн баримт бичигт тусгасан байдаг. Энэ баримт бичгүүд сэтгүүл зүйн деонтологийн үндэс, гол үзэл ба-римтлалын тусгал, тайлбар, агуулга учраас сэтгүүлчдийн ямар ч нийгэмлэг түүнгүйгээр оршин тогтнох боломжгүй юм.

Сэтгүүлчийн зайлшгүй байх ёстой зан байдлын хэмжээ, хязгаарыг тодорхойлдог баримт бичгүүд деонтологийн хүрээнд зөвхөн онолын талаас анхаарал татах төдийгүй, сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг бүхэлдээ болон түүний салбар нэгжүүдийн үйл ажиллагааны "удирдан чиглүүлэгч" баримт бичгүүдэд өндөр төвшинд тусгалаа олсон байх шаардлагатай. Хэм хэмжээ, дүрэм журам бол янз бүрийн хэв маягийн шинжтэй байдаг бөгөөд нэг хэсэг нь хууль эрхийн актын шинжтэй, хоёр дахь нь ёс суртахууны хүрээнд үйлчилдэг, гурав дахь нь редакцийн дотоод үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм, дөрөв дэх нь өөрөө өөрийгөө зохицуулахад чиглэгдсэн цэвэр субъектив шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, деонтологи хууль эрхийн актаас эхлээд мэргэжлийн ёс зүйн зарчим хүртэлх хэм хэмжээний бүх хэв маягтай холбоотой гэсэн үг юм.

Орчин үеийн сэтгүүл зүйн практикт тулгарч буй нэлээд нарийн төвөгтэй асуудлын нэг бол деонтологийн баримт бичгийн бүтцийн тухай асуудал мөн. Судлаачид болон сэтгүүлчдийн нэг хэсэг нь бүх сэтгүүлчдэд нэгэн зэрэг үйлчилдэг нэгдсэн баримт бичиг

шаардлагатай гэж үздэг бөгөөд энэ нь ОНМХ-үүдийн нийгмийн байр суурь, үзэл бодлын чиг баримжаа, ОНМХ-үүдийн системд эзлэх байр зэргийн ялгаа нэг их ирээдүйтэй зүйл биш гэсэн санал, дүгнэлттэй холбоотой юм. Нөгөө хэсэг нь ОНМХ-үүдийн хоорондох ялгаа зайлшгүй байх ёстой зүйл учраас деонтологийн нэг биш хэд хэдэн баримт бичиг шаардлагатай гэж үздэг байна. Ийм баримт бичгүүдийн цөм нь ажиллаж буй ХМХ-үүдийн ялгаанаас үл шалтгаалан сэтгүүлчдийн мэргэжлийн үүргийн утга учир, түүний биелэлтийн шинж чанар, ХМХ-үүдийн үйл ажиллагааны хэм хэмжээг тусгасан зарчим байх ёстой юм. Ийм баримт бичиг олон улсын шинжтэй ч байж болно. Хамгийн гол зорилго бол бүх төрлийн хууль эрхийн, ёс зүйн, захиргааны болон бусад деонтологийн шинжтэй баримт бичгийг нэгтгэсэн мэдээллийн сан байгуулах явдал юм. Барууны орнуудад энэ ажил аль хэдийд эхэлсэн бөгөөд ОХУ-д ч нэлээд эрчимтэй яригдаж байгааг хэлэх хэрэгтэй. Мөн сүүлийн жилүүдэд сэтгүүлчийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын эмхэтгэл, сэтгүүлчийн ёс зүйн сурах бичиг, гарын авлага, орчуулгын бүтээлүүд хэвлэгдэн гарсан нь деонтологийн асуудлыг боловсруулахад тодорхой нөлөө үзүүлэх болно. Мөн сэтгүүлчийн үүрэг, хариуцлага, ёс зүйн асуудлын хүрээнд янз бүрийн төсөл хэрэгжиж, сургалт семинар зохион байгуулагдаж буйн хамт "Сэтгүүлчийн ёс зүй", "ОНМХ-ийн эрх зүйн зохицуулалт" зэрэг хичээлийг сэтгүүлч бэлтгэдэг зарим их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулсан нь деонтологийн асуудлыг ойлгох, тодорхой төсөөлөл олж авахад чухал үүрэгтэй юм. Гэхдээ деонтологийн хүрээнд одоо үйлчилж буй баримт бичгүүд системгүй, бүрэн төгс, боловсронгуй бус байгааг хэлэх хэрэгтэй. Тиймээс дээрх баримт бичиг, ном, бүтээлүүдээс деонтологийн хүрээнд багтдаг асууд-

луудыг сонгон авч, системчлэх замаар бүгдээрээ хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг боловсруулах шаардлагатай байна. Дараагийн алхам бол хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнүүдийг нэгтгэж, Сэтгүүлчдийн зан байдлын харти маягийн баримт бичгийг боловсруулах явдал юм.

Өнөөдөр засаглалын институт болон ОНМХ-үүдийн хооронд тодорхой хэмжээний зөрчил байгаа нь ажиглагддаг. Төр,

засаг ХМХ-ийн үйл ажиллагааг эрх зүйн актуудын тусламжтайгаар гадна талаас нь зохицуулахыг оролддог бол сэтгүүлчид болон эрхлэн гаргагчид (эзэд) төр, засгийн зүгээс үзүүлж байгаа зохицуулалтыг аль болохоор хязгаарлаж, сэтгүүлчдийн байгууллагын үйл ажиллагааны деонтологийн асуудлыг өөрөө өөрийгөө зохицуулах аргаар шийдвэрлэхийг эрмэлзэж байна. Хэрэг дээрээ хууль тогтоомжийн тусламжтайгаар зохицуулж буй төрийн зохицуулалт болон ёс зүйн кодекс зэрэг хууль эрхийн бус баримт бичгүүдээр зохицуулж буй сэтгүүлчдийн дотоод зохицуулалт хоёр нь олон нийтийн мэдээллийн үйл ажиллагааны бүх хөдөлгөгч хүчин ухамсарлан ойлгож, хүлээн зөвшөөрсөн нэмэлт зарчмууд дээр үндэслэгдсэн байх ёстой. Ардчилсан иргэний нийгэмд төрийн зохицуулалт ба сэтгүүлчийн дотоод зохицуулалтын зарчмууд өөрийн гэсэн хэмжээ хязгаартай, судлагдахуунтай байдаг онцлогтой юм. Түүнийг зөрчсөн нөхцөлд нэлээд

ширүүн зөрчил, маргаан үүсэх болно. Манай оронд тийм зохицуулалтын зарчим үгүйлэгдэж байгаа учир алхам тутамдаа эсэргүүцэлтэй тулгарч, янз бүрийн зөрчил сөргөлдөөн үүсдэг. Үүний тод жишээ бол олон жил яригдсан Радио, телевизийн болон МОНЦАМЭ агентлагийн хууль одоо хүртэл батлагдаж чадаагүй байгаа явдал юм.

Энэ бол төр, засгийн түшмэлүү-

дийн ч, сэтгүүлчдийн ч деонтологийн ухамсар ихээхэн доогуур төвшинд байгаагийн илрэл мөн. Тиймээс томоохон хэмжээний деонтологийн баримт бичгийг бэлтгэхийн тулд сэтгүүлчдийн деонтологийн ухамсрыг дээшлүүлэх шаардлага тулгарч байна. Өөрөөр хэлбэл, гадаад болон дотоод зохицуулалтын дүрэм журам, зарчим, хэм хэмжээний та-

«

Өнөөдөр засаглалын институт болон ОНМХ-үүдийн хооронд зөрчил байгаа нь ажиглагддаг. Төр, засаг ХМХ-ийн үйл ажиллагааг эрх зүйн актуудын тусламжтайгаар гадна талаас нь зохицуулахыг оролддог бол сэтгүүлчид болон эрхлэн гаргагчид төр, засгийн зохицуулалтыг аль болохоор хязгаарлаж, сэтгүүлчдийн байгууллагын үйл ажиллагааны деонтологийн асуудлыг өөрөө өөрийгөө зохицуулах аргаар шийдвэрлэхийг эрмэлзэж байна.

»

лаар маш тодорхой төсөөлөлтэй байх явдал юу юунаас чухал юм. Ийм сэтгэл зүйн "өөрчлөлт, шинэчлэлтийн" хамт эрдэм шинжилгээ, судалгааны болон зохион байгуулалтын томоохон ажил хэрэгтэй.

Деонтологийн асуудал олон бүрэлдэхүүн хэсэгтэй учир Сэтгүүлчдийн харти деонтологийн зарчмуудын системийг бүрдүүлдэг эрх зүйн ба ёс суртахууны, улс төрийн ба уран бүтээлийн, зохион байгуулалтын ба сэтгэл зүйн талуудыг бүрэн хамарсан байх ёстой. Ийм Хартид юуны өмнө дараах үндсэн зарчмууд тусгалаа

олсон байх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүйн эзлэх байр, үүрэг;

- ОНМХ-ийн нийгэм-уран бүтээлийн, эрх зүйн, эдийн засгийн эрх чөлөөний мөн чанарын тодорхойлолт;

- ардчиллыг мэдээллээр хангах зарчмууд;

- нийгмийг үнэн бодитой, цаг үеэ олсон, бүрэн төгс мэдээллээр хангах үйл ажиллагааны чиглэл;

- хүлээн авагчдын мэдээлэл хүлээж авах боломжийн төлөө тавих анхаарал;

- нийгмийн янз бүрийн хүчнүүдийн байр суурь, үзэл бодлыг илэрхийлж чадахуйц ОНМХ-ийн олон ургальч үзэл;

- бүх ХМХ-ийн тэгш эрхийг хүлээн зөвшөөрөх, тэдний байр суурь, үзэл бодлыг хүндэтгэх;

- хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх хууль тогтоомжийн хүрээн дэх мэдээллийн бодлогын эрх чөлөө;

- мэдээллийн бодлогыг явуулахдаа хүлээцтэй, тэвчээртэй хандах;

- маргаан, мэтгэлцээн, шүүмжлэл явуулах хэрэгслүүдийг оновчтой ашиглах замаар нээлттэй яриа өрнүүлэх шаардлага;

- ярианд оролцогчдын байр суурь, үнэлэлт дүгнэлтийг үнэн зөв илэрхийлэх;

- аливаа ХМХ-ийн дэвшүүлэн тавьсан нийгмийн ач холбогдолтой асуудлын талаарх ярианд зайлшгүй оролцох;

- бусад ХМХ-ийн дэвшүүлсэн чухал асуудлыг дэмжих;

- мэдээллийн аюулгүй байдлын шаардлагуудыг биелүүлэх;

- редакци доторх харилцааны ардчилал;

- редакци болон түүний ажилтнуудын хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага, хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага;

- төрийн болон олон нийтийн байгууллагын зүгээс мэдээллийн дэг журмыг сахин биелүүлэх үйл явцад хяналт тавих, ажиглалт хийх боломж зэрэг болно. Энэ бол зөвхөн үндсэн зарчмууд бөгөөд баримт бичгийг боловсруулах явцад үүнийг улам гүнзгийрүүлж баяжуулах шаардлагатай юм.

Ишлэл

¹ См. Прохоров Е. П. Журналистика и демократия. М. 2001. С. 240.

² Бентам И. Введение в основания нравственности и законодательства. М. 1998. С. 375.

³ Там же. С. 339.

⁴ Иванов В. Г. История этики древнего мира. Л. 1980. С. 146.

⁵ См. Петров Н. Н. Вопросы хирургической деонтологии. М. 1956. С. 167-145.

⁶ Кукушкин В. М. Полицейская деонтология. М. 1994. С. 21.

⁷ Media and Democracy. Strasbourg. 1998. P. 75.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Авраамов Д. С. 1999. Профессиональная этика журналиста. М.
2. Арон Р. 1993. Демократия и тоталитаризм. М.
3. Бентам И. 1998. Введение в основания нравственности и законодательства. М.
4. Бухарцев В. 1971. Вопросы профессиональной этики журналиста. Свердловск.
5. Горшенев В. М., Бендик И. В. 1988. Юридическая деонтология. Киев.
6. Иванов В. Г. 1980. История этики древнего мира. Л.
7. Зулькафиль М., Чойсамба Ч. 2004. Сэтгүүлчийн ёс зүй. УБ.
8. Ламбет Э. Б. 1998. Приверженность журналистскому долгу: об этическом подходе к журналистской профессии. М.

9. К у к у ш к и н В. М. 1994. Полицейская деонтология. М.
10. П е т р о в Н. Н. 1956. Вопросы хирургической деонтологии. М.
11. 1997. Правовое поле журналиста. М.
12. П р о х о р о в Е. П. 1998. Введение в теорию журналистики. М.
13. П р о х о р о в Е. П. 2001. Демократия и журналистика. М.
14. D e n n i s E., M e r r i l l J. 1996. Media Debates: Issues in Mass Communication. New York.
15. 1998. Media and Democracy. Strasbourg.
16. M e r r i l l J. 1997. Journalism Ethics. N.-Y. St. Martin Press.
17. K e a n J. 1991. The Media and Democracy. L.

Резюме

Одной из важных проблем современной демократической журналистики является раз-

работка проблем деонтологии журналистики. Введенный в научный оборот более 150 лет тому назад термин "деонтология" в наши дни как будто начинает жить новой жизнью, приобретает новый вес и новое, расширяющееся и уточняющееся, значение в самых разных областях, в том числе и в журналистике. Именно этой важнейшей теоретической и практической проблеме журналистики посвящена эта статья. Автор, опираясь на исторические факты, документы норм поведения журналистической деятельности, научные труды, примеры из практики, практические рекомендации учёных, исследователей, раскрывает сущность, содержание и объём этого понятия и определяет составные части, факторы, влияющие на его содержание. Также определяются основные принципы деонтологии современной журналистики и на основе этих принципов автор предлагает создать Хартию поведения журналистов Монголии.